

**АПУ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу
бэлтгэсэн
Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр**

Агуулга

Хараат бус Аудиторын тайлан

Нэгтгэсэн санхүүгийн тайлангууд

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	1
Нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	3
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	4
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга	
1 АПУ ХК болон түүний охин компаниудын үйл ажиллагаа	7
2 Тайлан бэлтгэх үндэслэл	8
3 Өмнөх тайлант үеийн дахин тайлагнал	9
4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд ашигласан нөлөө бүхий бүртгэлийн тооцоолол болон үнэлэлт	17
5 Шинэ буюу шинэчилсэн стандарт болон тайлбар тодруулгуудын хэрэгжилт	19
6 Нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартууд	20
7 Сегментийн мэдээлэл	21
8 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ	25
9 Үндсэн хөрөнгө	28
10 Биет бус хөрөнгө болон гүүдвил	32
11 Өмчийн аргаар бүртгэсэн хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт	35
12 Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	37
13 Биологийн хөрөнгө	37
14 Бусад эргэлтийн бус хөрөнгө	38
15 Бараа материал	38
16 Дансны болон бусад авлага	39
17 Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	41
18 Хувьцаат капитал, нэмж төлөгдсөн капитал ба бусад нөөцүүд	41
19 Зээл	43
20 Түрээс	47
21 Дансны болон бусад өглөг	49
22 Ажилчдын тэтгэмж	49
23 Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулга	51
24 Орлого	52
25 Борлуулалтын өртөг болон борлуулалт удирдлагын зардал	53
26 Бусад орлого болон зардал	54
27 Санхүүгийн орлого болон санхүүгийн зардал	55
28 Орлогын албан татварын зардал	56
29 Нэгж хувьцаанд ногдох ашиг	59
30 Хөрөнгө оруулалтын болон санхүүгийн үйл ажиллагааны томоохон мөнгөн бус гүйлгээ	60
31 Болзошгүй өр төлбөр ба үүрэг	60
32 Санхүүгийн эрсдэлийн удирдлага	61
33 Бодит үнэ цэнийн тодруулга	66
34 Тайлант үеийн дараах үйл явдлууд	68

Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Группийн Удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.


АПУ ХК болон түүний охин компаниуд (цаашид хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Группийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Группийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 34-д дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.


Мөн АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Группийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

АПУ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс Группийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.


П. Батсайхан

Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн Дарга


Ц. Эрдэнэбилэг
Гүйцэтгэх
Захирал


Г. Энхбилэг

Санхүү Эрхэлсэн
Захирал

Монгол Улс, Улаанбаатар хот

2026 оны 4 дүгээр сарын 8-ний өдөр



Хараат бус Аудиторын Тайлан

АПУ Хувьцаат Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдэд

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь АПУ Хувьцаат Компани (“Компани” гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь “Групп” гэх)-ын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Группийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь дараах хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан;
- 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд болон бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар энэхүү тайлангийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Монгол
Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг-8,
Сүхбаатарын талбай, Сэнтрал Тауэр, 6 давхарт 601
тоот, Утас: +976 70009089

www.pwc.com/mn

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК, Улаанбаатар хотод бүртгэлтэй, бүртгэлийн
дугаар 5357128

Дүгнэлтийн үндэслэл (үргэлжлэл)

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэж байна.

Хараат бус байдал

Нийтийн ашиг сонирхол бүхий аж ахуйн нэгжүүдийн аудитад хамаарах Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат бус байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (НБЁЗОУСЗ-ийн Дүрэм)-ийн дагуу Группээс бид хараат бус болно. Бид НБЁЗОУСЗ-ийн дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Аудитын арга барил

Хураангуй



Группийн материаллаг байдлын ерөнхий түвшин: 12,698,000 мянган төгрөг нь тайлант жилийн татварын өмнөх ашгийн 5% байна.

Аудитын ажлыг нийт зургаан бүрэлдэхүүн нэгжид гүйцэтгэсэн бөгөөд бүгдэд нь бүрэн хамрах хүрээтэй аудитын горимуудыг хэрэгжүүлсэн. Эдгээрийн нэг нь хамтарсан компани байсан. Аудитын хамрах хүрээ нь Группийн нийт орлогын ойролцоогоор 99%, Группийн татварын өмнөх ашгийн 98%-ийг хамарсан.

- Группийн хөрөнгө оруулалтын хяналтын үнэлгээ

- Хамтарсан болон тусдаа хариуцлагын талаарх өр төлбөрийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Аудитын төлөвлөлтийн хүрээнд бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тооцоолсон. Ялангуяа тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаарх таамаглалыг агуулсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолол зэрэг удирдлагын хийсэн томоохон үнэлэлт, дүгнэлтийг харгалзан үзсэн. Бид аудитын бүх үе шатанд бусад асуудлаас гадна гүйцэтгэх удирдлагын эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг батлах нотолгоо байгаа эсэхийг анхаарч үзсэн.

Материаллаг байдал

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдлын түвшин нөлөөлдөг. Аудит нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид эсэхэд үндэслэлтэй баталгаа олж авахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц бол тэдгээрийг материаллаг гэж үзнэ.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд тулгуурлан Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад бүхэлд нь хамаарах материаллаг байдлын тодорхой тоон босго үзүүлэлтийг тогтоосныг доорх хүснэгтэнд харуулав. Эдгээрийг чанарын хүчин зүйлсийн хамт харгалзаж үзсэнээр бид аудитын хамрах хүрээ, гүйцэтгэх горимуудын шинж чанар, хутацаа, хэмжээг тогтоож буруу илэрхийлэл байгаа бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад бүхэлдээ хэрхэн нөлөөлж буйг тодорхойлоход тусалдаг.

Группийн материаллаг байдлын ерөнхий түвшин	12,698,000 мянган төгрөг
Бид хэрхэн тодорхойлсон талаар	2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Группийн татварын өмнөх ашгийн 5%
Материаллаг байдлын түвшинг тооцсон үндэслэл	Групп ашигтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд татварын өмнөх ашиг нь нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн хувьд гүйцэтгэлийн гол хэмжүүр болдог тул татварын өмнөх ашгийг хамгийн тохиромжтой суурь үзүүлэлт гэж үзсэн. Бид энэхүү суурь үзүүлэлтэд 5%-ийг сонгосон бөгөөд энэ нь тухайн салбарын ашигт чиглэсэн компаниудад түгээмэл хэрэглэгддэг материаллаг байдлын тоон босго үзүүлэлттэй нийцэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж бидний мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитынхаа хүрээнд бүхэлд нь авч үзэн дүгнэлтээ гаргасан бөгөөд тус бүрчлэн дүгнэлт гаргадаггүй болно.

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Группийн хөрөнгө оруулалтын хяналтын үнэлгээ - Тодруулга 3, Тодруулга 4 болон Тодруулга 12-ыг харна уу.

Групп нь хамтын засаглалын зохицуулалтад хамаарах нэг хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжид түүний хувьцааны цөөнхийн эзэмшлийн хувийг эзэмшдэг. Энэ хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж нь хувьцаа эзэмшигч талуудын төлөөллөөс бүрдсэн Төлөөлөн удирдах зөвлөлөөр дамжуулан удирдлагын үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг бөгөөд тухайн аж ахуйн нэгжийн холбогдох үйл ажиллагаатай холбоотой чухал шийдвэрүүдийг гаргахад бүх хувьцаа эзэмшигч талуудын санал нэгтэй зөвшөөрөл шаардлагатай байдаг. Мөн энэхүү засаглалын зохицуулалт нь хувьцаа эзэмшигчдийн хооронд хийсэн худалдан авах болон худалдах сонголтын эрхийг агуулж байгаа бөгөөд эдгээр нь шийдвэр гаргах эрх болон боломжит хяналтыг үнэлэхэд төвөгтэй байдлыг үүсгэдэг. Гэсэн хэдий ч хувьцаа эзэмшигчдийн хооронд хийсэн энэхүү худалдан авах болон худалдах сонголтын эрх нь Төлөөлөн удирдах зөвлөлийн нэмэлт суудал олгохгүй, мөн хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн шийдвэр гаргах дүрмийг өөрчлөхгүй бөгөөд засаглалын зохицуулалтын аливаа өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд бүх хувьцаа эзэмшигчдийн санал нэгтэй зөвшөөрөл шаардлагатай болдог.

Групп нь хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийг хянаж байгаа эсэх, хамтран хянаж байгаа эсэх, эсвэл хяналтыг хэрэгжүүлэхгүй байгаа эсэх талаарх удирдлагын дүгнэлт нь ихээхэн үнэлэлт, дүгнэлт шаардсан асуудал бөгөөд энэхүү хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийг нэгтгэн тайлагнах эсвэл хамтарсан компанийн хэлбэрээр өмчийн аргыг ашиглан бүртгэх эсэхийг тодорхойлдог. Иймд энэхүү дүгнэлт нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг.

Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд энэхүү гол асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар

Аудитын гол асуудлыг шийдвэрлэх хүрээнд бид дараах аудитын горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын зохицуулалттай холбоотой баримт бичгүүдийг, тухайлбал хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэм, холбогдох засаглалын баримт бичгүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, саналын эрх, мөн холбогдох үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах зөвшөөрлийн босго түвшинг хянаж шалгасан.
- Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгжийн холбогдох үйл ажиллагаанд хамаарах шийдвэр гаргах шаардлагуудыг үнэлж, аль нэг хувьцаа эзэмшигч нь эдгээр үйл ажиллагаануудыг одоогоор бие даан чиглүүлэн удирдах чадвартай эсэхийг үнэлсэн.
- Хөрөнгө оруулалтын аж ахуйн нэгж болон хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулсан хэд хэдэн гэрээг хянаж үнэлсэн, үүнд эдгээр гэрээнүүдийн хэрэгжих боломжит байдал, дуусгавар болох хугацаа байхгүй байх, засаглалтай холбоотой нөхцөлүүдийг багтаасан бөгөөд эдгээр гэрээнүүдэд тусгагдсан олон төрлийн сонголтын эрх нь одоогийн хяналтыг бий болгох бодит боломжит саналын эрхийг олгож байгаа эсэхийг үнэлсэн.
- Хөрөнгө оруулалтад ашигласан нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн зохистой байдлыг үнэлсэн, үүнд хамтарсан компани гэж ангилах болон хэрэв боломжтой бол өмчийн аргыг ашиглах асуудлыг багтаасан.
- Ач холбогдол бүхий дүгнэлтийг багтаасан холбогдох тодруулгуудыг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан.

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Хамтарсан болон тусдаа хариуцлагын талаарх өр төлбөрийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт - Тодруулга 3, Тодруулга 4 болон Тодруулга 19-ийг харна уу.

2023 оны 5 дугаар сард Групп нь бусад холбоотой талуудтай хамтран үүрэг хүлээгч байдлаар санхүүгийн байгууллагатай зээлийн гэрээ байгуулсан. Зээлийн гэрээнд хамтарсан болон тусдаа хариуцлага хүлээх заалтууд багтсан бөгөөд эдгээр заалтуудын дагуу хамтран үүрэг хүлээгч бүр нь зээлийн хүрээнд төлөх өглөгийн нийт дүнгийн эцсийн үлдэгдэлд бүрэн хэмжээгээр гэрээний хариуцлагыг хүлээдэг.

Энэхүү зохицуулалтын нягтлан бодох бүртгэлийн зохих бүртгэл хөтлөлт, тайлагналын аргачлалыг тодорхойлох нь мэргэжлийн дүгнэлт шаардсан асуудал бөгөөд үүнд хамтран үүрэг хүлээгч бүрийн хувьд энэхүү зохицуулалт нь санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэх, түүнтэй холбоотой хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, мөн тодруулгын шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлууд багтана. Энэхүү асуудал нь Группийн өр төлбөр, санхүүгийн зардал болон тодруулгуудад (үүнд ангилал болон гэрээний нөхцөлтэй холбоотой тодруулгын мэдээллийг оролцуулан) ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг.

Бидний гүйцэтгэсэн аудитын горимууд энэхүү гол асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар

Аудитын гол асуудлыг шийдвэрлэх хүрээнд бид дараах үндсэн аудитын горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээ болон хамтарсан болон тусдаа хариуцлагын заалт болон хамтран үүрэг хүлээгч бүрийн гэрээний үүргийг хянаж шалгасан.
- Зохицуулалтын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, дансны бичилтийг үнэлж, хамтран үүрэг хүлээгчийн үүрэг нь Группийн санхүүгийн өр төлбөрийн тодорхойлолтыг хангаж байгаа эсэхийг тодорхойлсон.
- Өр төлбөрийн анхны болон дараах үеийн хэмжилтийн суурийг үнэлсэн, үүнд гүйлгээний зардал, хорогдуулалтын өртөг болон хуримтлагдсан хүүгийн хүлээн зөвшөөрөлтийг багтаасан.
- Гэрээний нөхцөлтэй холбоотой заалтуудыг хянаж, НББОУС 1-ийн шаардлагын дагуу өр төлбөрийн ангилал болон холбогдох тодруулгууд зохистой эсэхийг үнэлсэн.
- Ач холбогдол бүхий дүгнэлтийг багтаасан холбогдох тодруулгуудыг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг шалгасан.

Бид Группийн аудитын хамрах хүрээг хэрхэн тодорхойлсон тухай

Бид Группийн бүтэц, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт ба хяналт, мөн Группийн үйл ажиллагаагаа явуулж буй салбарын онцлогийг харгалзан, нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар бүхэлд нь дүгнэлт гаргах боломжийг хангахуйц хангалттай хэмжээний аудитын ажлыг гүйцэтгэхийн тулд аудитын хамрах хүрээг тохируулан тодорхойлсон.

Аудит хамрах хүрээнд нийт зургаан бүрэлдэхүүн нэгжийг хамарсан бөгөөд бүгдэд нь бүрэн хамрах хүрээтэй аудитын горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд өмчийн аргыг ашиглан нягтлан бодох бүртгэлээ хөтөлдөг нэг хамтарсан компанийг багтаасан. Аудитын хамрах хүрээнд багтсан бүрэлдэхүүний бүх нэгжүүд Монгол Улсад байрлалтай бөгөөд тэдгээрийн аудитын ажлыг Группийн аудитын баг гүйцэтгэсэн.

Гадаадад байрлах дөрвөн охин компанийг тус бүрдээ болон нийт дүнгээрээ Группийн хувьд ач холбогдол бүхий гэж үзээгүй тул аудитын хамрах хүрээнээс хассан.

Гүйцэтгэсэн аудитын ажил нь Группийн нэгтгэсэн нийт орлогын ойролцоогоор 99%, Группийн нэгтгэсэн татварын өмнөх ашгийн 98%-ийг хамарсан.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Энэхүү аудиторын тайланг гаргах өдрөөс хойш бид хүлээн авахаар хүлээгдэж буй бусад мэдээлэл гэдэгт 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны Группийн Жилийн тайлан (үүнд нэгтгэсэн санхүүгийн тайлан болон аудиторын тайлан хамаарахгүй болно) орно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргахгүй болно.

Нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудиттай холбоотойгоор бидний хүлээх үүрэг хариуцлага нь дээр дурдсан бусад мэдээллийг уншиж танилцах бөгөөд ингэхдээ бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан болон аудитын явцад олж авсан бидний ойлголттой материаллаг зөрүүтэй эсвэл ямар нэг байдлаар материаллаг буруу илэрхийлэгдсэн эсэхийг шалгаж үзэх юм.

2025 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант хугацааны Группийн Жилийн тайланг уншиж танилцах үед хэрэв бид энэхүү бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлэл байна гэж үзвэл засаглах эрх бүхий этгээдэд энэ талаар тайлагнах үүрэгтэй.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг СТОУС Нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Групп үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвартай эсэхийг үнэлэх, шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхтэй холбоотой асуудлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулах, Группийг татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй болсноос бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх бүхий этгээд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь нэгтгэсэн санхүүгийн тайлангууд бүхэлдээ залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгааг олж авах, мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаа гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл бүрийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба эдгээр нь тус бүртээ эсвэл нийтдээ нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхүйц байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх явцдаа бид мэргэжлийн үнэлэмжүүдийг гаргадаг ба аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас ханддаг. Мөн бид:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон эрх мэдлээ ашиглан дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдийг агуулсан байдаг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Группийн дотоод хяналтын үр нөлөөг дүгнэх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцоолуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой мөрдсөн эсэх, мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн, үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх Группийн чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэсэн үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэдэг. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал байна гэж үзвэл аудиторын тайландаа нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулгыг хангалтгүй гэж үзвэл дүгнэлтээ өөрчлөх шаардлага гардаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоондоо үндэслэн бид дүгнэлт өгдөг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болоход хүргэж болно.

- Тодруулгуудыг оролцуулан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг үнэлдэг ба холбогдох ажил гүйлгээ болон үйл явдлуудыг нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахын тулд Группийн доторх байгууллагууд болон бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй хамааралтай аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Групп аудитын зорилгоор гүйцэтгэсэн тус аудитын ажлын баримтыг нягтлан шалгаж, чиглүүлэх нь бидний үүрэг мөн. Бид гаргасан аудитын дүгнэлтэндээ хариуцлага хүлээнэ.

Бид төлөвлөсөн аудитын ажлын хамрах хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдол болон бусад асуудлуудыг багтаагаад аудитын томоохон илрүүлэлтийн талаар засаглах эрх бүхий этгээдтэй харилцдаг.

Бид мөн хараат бус байдалд тавигдах ёс зүйн хэм хэмжээнд хэрхэн нийцэж ажилласан, хараат бус байдал алдагдах үндэслэлтэй эргэлзээ төрүүлэхүйц бүхий л харилцаа болон бусад бүхий л хүчин зүйлсийн талаар, шаардлагатай нөхцөлд тэдгээрээс хараат бус байдлыг хэрхэн хамгаалах арга хэмжээг авч ажилласан мэдэгдлийг засаглах эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг.

Засаглах эрх бүхий этгээдтэй харилцсан асуудал дотроос тайлант үеийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудлуудыг тодруулж, тэдгээрийг аудитын гол асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж, дүрэм журамд аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлснээр үүсэх сөрөг үр дагавар нь түүнийг мэдээлснээр олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү гэж үзэх нэн ховор тохиолдлоос бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тусгадаг.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Шаукат Тапиа болно.

Гарын үсэг зурсан:



ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапиа

Партнер

ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот
2026 оны 4 сарын 8-ны өдөр

АПУ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025.12.31	2024.12.31 дахин тайлагнасан	2024.01.01 дахин тайлагнасан
ХӨРӨНГӨ				
Эргэлтийн бус хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	9	539,731,248	445,168,707	383,756,728
Биет бус хөрөнгө ба гүүдвил	10	52,879,457	58,745,632	65,176,163
Өмчийн аргаар бүртгэсэн хамтарсан компанид оруулсан хөрөнгө оруулалт	11	75,728,263	74,507,084	75,307,001
Өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалт	12	4,101,047	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	28	1,192,938	439,755	980,650
Биологийн хөрөнгө	13	368,002	628,447	623,520
Бусад эргэлтийн бус хөрөнгө	14	43,681,959	10,596,967	-
Нийт эргэлтийн бус хөрөнгө		717,682,914	590,086,592	525,844,062
Эргэлтийн хөрөнгө				
Бараа материал	15	174,654,172	173,046,112	187,228,055
Дансны болон бусад авлага	16	109,994,124	107,062,144	58,593,437
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	17	108,972,079	78,539,186	87,916,831
Урьдчилж төлсөн төлбөр	16	14,878,087	32,184,801	26,011,026
Урьдчилж төлсөн орлогын албан татвар	28	5,953,392	740,508	7,833,375
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		216,000	411,000	642,000
Нийт эргэлтийн хөрөнгө		414,667,854	391,983,751	368,224,724
НИЙТ ХӨРӨНГӨ		1,132,350,768	982,070,343	894,068,786
ЭЗДИЙН ӨМЧ				
Хувьцаат капитал	18	106,418	106,418	106,418
Нэмж төлөгдсөн капитал	18	339,442,756	339,442,756	339,442,756
Нэгдлийн нөөц	18	(112,795,804)	(112,795,804)	(112,795,804)
Дахин үнэлгээний нөөц	18	155,109,751	156,572,931	157,839,026
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	18	745,860	(457,461)	(56,565)
Хуримтлагдсан ашиг		459,683,040	389,161,901	273,675,919
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		842,292,021	772,030,741	658,211,750
Өр төлбөр				
Урт хугацаат өр төлбөр				
Урт хугацаат зээл	19	160,403,264	61,383,927	107,392,420
Хойшлогдсон татварын өр төлбөр	28	19,126,071	22,522,676	29,811,123
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	20	15,256,797	11,194,213	3,923,728
Бусад өглөг	21	502,283	5,877,501	-
Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөц сан	22	1,672,120	1,308,824	989,976
Нийт урт хугацаат өр төлбөр		196,960,535	102,287,141	142,117,247

АПУ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
Нэгтгэсэн Санхүүгийн Байдлын Тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2025.12.31	2024.12.31	2024.01.01
			Дахин тайлагнасан	Дахин тайлагнасан
Богино хугацаат өр төлбөр				
Дансны болон бусад өглөг	21	62,963,725	66,918,763	48,815,086
Богино хугацаат зээл	19	23,440,179	18,956,263	36,293,828
Богино хугацаат түрээсийн өр төлбөр	20	5,226,123	6,666,123	6,884,285
Хойшлогдсон орлого		508,301	-	-
Орлогын албан татварын өглөг	28	655,326	14,835,724	1,562,784
Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж	22	304,558	375,588	183,806
Нийт богино хугацаат өр төлбөр		93,098,212	107,752,461	93,739,789
НИЙТ ӨР ТӨЛБӨР		290,058,747	210,039,602	235,857,036
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		1,132,350,768	982,070,343	894,068,786

2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр баталж, гарын үсэг зурсан.

Цэвээнжавын Эрдэнэбилэг
Гүйцэтгэх Захирал

Гончигийн Энхбилэг
Санхүү Эрхэлсэн Захирал

АПУ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Мянган төгрөгөөр	Тод- руулга	2025	2024 дахин тайлагнасан
Борлуулалтын орлого	24	1,320,663,900	1,340,375,302
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	25	(748,938,545)	(774,356,838)
Нийт ашиг		571,725,355	566,018,464
Борлуулалт болон удирдлагын зардал	25	(290,763,517)	(258,522,468)
Санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын цэвэр зардал	32	(10,419,215)	(158,304)
Бусад орлого	26	7,441,324	6,460,822
Бусад зардал	26	(2,443,280)	(1,582,719)
Үйл ажиллагааны ашиг		275,540,667	312,215,795
Хамтарсан компанийн үр дүнгийн хувь	32	(20,189,168)	(18,913,988)
Санхүүгийн орлого	27	9,105,685	3,998,999
Санхүүгийн зардал	27	(10,482,278)	(12,459,014)
Татварын өмнөх ашиг		253,974,906	284,841,792
Орлогын албан татварын зардал	28	(46,117,497)	(65,094,427)
ТАЙЛАНТ ЖИЛИЙН АШИГ		207,857,409	219,747,365
Бусад дэлгэрэнгүй орлого:			
<i>Ашиг, алдагдал руу тайлант үеийн дараа дахин ангилагдах зүйлс:</i>			
Гадаад валютын хөрвүүлэлтийн ханшийн зөрүү		1,203,321	(400,896)
<i>Ашиг, алдагдал руу дахин ангилагдахгүй зүйлс:</i>			
Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн дахин хэмжилт		(455,849)	(173,503)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		208,604,881	219,172,966
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО			
Ашгийн ногдох хэсэг:			
Компанийн хувьцаа эзэмшигчдэд		207,857,409	219,747,365
Тайлант жилийн ашиг		207,857,409	219,747,365
Нийт дэлгэрэнгүй орлогын ногдох хэсэг:			
Компанийн хувьцаа эзэмшигчдэд		208,604,881	219,172,966
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		208,604,881	219,172,966
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (нэгж хувьцаа, төгрөгөөр)	29	195.32	206.49

АПУ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Группийн хувьцаа эзэмшигчдэд ногдох хэсэг								
Мянган төгрөгөөр	Тод-руулга	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Нэгдлийн нөөц	Дахин үнэлгээний нэмэгдлийн нөөц	Гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт өмчийн дүн
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өмнө тайлагнасан үлдэгдэл		106,418	339,442,756	(112,795,804)	157,839,026	(56,565)	295,703,808	680,239,639
Алдааны залруулга (татварын дараах цэвэр дүнгээр)	3	-	-	-	-	-	(22,027,889)	(22,027,889)
2024 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)		106,418	339,442,756	(112,795,804)	157,839,026	(56,565)	273,675,919	658,211,750
Тайлант жилийн ашиг (дахин тайлагнасан)		-	-	-	-	-	219,747,365	219,747,365
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	(400,896)	(173,503)	(574,399)
2024 оны нийт дэлгэрэнгүй орлого (дахин тайлагнасан)		-	-	-	-	(400,896)	219,573,862	219,172,966
Зарласан ногдол ашиг	18	-	-	-	-	-	(105,353,975)	(105,353,975)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлэх	18	-	-	-	(1,266,095)	-	1,266,095	-
2025 оны 1 дүгээр сарын 1-ний үлдэгдэл (дахин тайлагнасан)		106,418	339,442,756	(112,795,804)	156,572,931	(457,461)	389,161,901	772,030,741
Тайлант жилийн ашиг		-	-	-	-	-	207,857,409	207,857,409
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	1,203,321	(455,849)	747,472
2025 оны нийт дэлгэрэнгүй орлого		-	-	-	-	1,203,321	207,401,560	208,604,881
Зарласан ногдол ашиг	18	-	-	-	-	-	(138,343,601)	(138,343,601)
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлэх	18	-	-	-	(1,463,180)	-	1,463,180	-
2025 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл		106,418	339,442,756	(112,795,804)	155,109,751	745,860	459,683,040	842,292,021

АПУ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тод- руулга	2025	2024 Дахин тайлагнасан
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант жилийн ашиг		207,857,409	219,747,365
Тохируулгууд:			
Орлогын албан татварын зардал	28	46,117,497	65,094,427
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн зардал	27	3,692,489	2,448,287
Зээлийн хүүгийн зардал	27	5,882,798	8,411,364
Өмчөөрх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	12,32	9,698,953	-
Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөцийн дискаунтын чөлөөлөлт	27	186,091	184,571
Хүүгийн орлого	27	(6,227,846)	(3,998,999)
Гадаад валютын ханш хөрвүүлэлтийн зөрүү		1,088,159	331,258
Элэгдлийн зардал		54,930,626	51,325,488
Хорогдуулалтын зардал		6,974,917	7,118,681
Түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтийн олз	26	(109,209)	(589,917)
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	26	864,379	296,277
Зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз	27	(2,877,839)	-
Биологийн хөрөнгө данснаас хассаны гарз	13	225,812	71,809
Өмчийн аргаар бүртгэсэн хамтарсан компанийн үр дүнгийн хувь	11	20,189,168	18,913,988
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		348,493,404	369,354,599
Дансны болон бусад авлагын (өсөлт)		(8,314,640)	(48,177,624)
Бараа материалын (өсөлт)/бууралт		(1,608,060)	14,181,943
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн бууралт		195,000	231,000
Урьдчилж төлсөн төлбөрийн бууралт/(өсөлт)		17,306,714	(6,173,775)
Дансны болон бусад өглөгийн (бууралт)/өсөлт		(8,212,250)	17,399,651
Ажилчдын тэтгэвэр, тэтгэмжийн нөөц сангийн (бууралт)/өсөлт		(349,674)	152,556
Ажлын капиталын өөрчлөлт		347,510,494	346,968,350
Төлсөн зээлийн хүү	23	(8,086,671)	(8,798,848)
Төлсөн түрээсийн өр төлбөрийн хүү	23	(3,692,489)	(2,448,287)
Хүлээн авсан хүү	27	6,227,846	3,998,999
Төлсөн орлогын албан татвар		(69,660,567)	(51,476,172)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		272,298,613	288,244,042
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан үндсэн хөрөнгө		(165,752,146)	(98,642,055)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(1,108,742)	(688,150)
Борлуулсан биологийн хөрөнгө	13	95,907	-
Худалдан авсан биологийн хөрөнгө	13	(61,276)	(76,736)
Борлуулсан үндсэн хөрөнгө		19,731	-
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр үнэлэгдэх өмчийн хэрэглүүрийн худалдан авалт	12	(9,698,953)	-
Хамтарсан компанид оруулсан нэмэлт хөрөнгө оруулалт	11	(19,513,078)	(17,557,325)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(196,018,557)	(116,964,266)

АПУ ХК болон түүний охин компаниуд
Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тод- руулга	2025	2024 Дахин тайлагнасан
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Авсан зээл	23	127,911,028	14,300,000
Зээлийн эргэн төлөлт	23	(28,588,613)	(77,975,786)
Компанийн хувьцаа эзэмшигчдэд төлсөн ногдол ашиг	23	(137,671,668)	(104,867,661)
Түрээсийн ер төлбөрийн эргэн төлөлт - үндсэн төлбөр	23	(7,797,419)	(11,542,286)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(46,146,672)	(180,085,733)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)/			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эхний үлдэгдэл		30,133,384	(8,805,957)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эхний үлдэгдэл		78,539,186	87,916,831
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн зөрүү		299,509	(571,688)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн тайлант жилийн эцсийн үлдэгдэл	17	108,972,079	78,539,186

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд тусгагдаагүй мөнгөн бус хөрөнгө оруулалтын болон санхүүжилтийн ажил гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг 30-р тодруулгаас харна уу.